



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/162/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2024 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580
Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид
Утас: 9511-2689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Ахлах аудитор Ш.Ганчимэг Утас: 99377360
Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10-11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12-13
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	15-16
7. Асуудлын бүртгэл.....	17
8. Төлбөрийн акт 01/138.....	18-19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 268

танай _____ ны № _____ т

ОРХОН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 93,510.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

БШУС-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/230 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хуваарилсан 11,114.6 мянган төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтээр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, сургалтын тоног төхөөрөмж худалдан авч санхүүгийн тайланд тусгасан байна.

006020591

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн хүрээнд “Шинэ багш”, “Шинэ ирээдүй”, “Шинэ хөдөө” дэд хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,925,908.06	157,469,544.91
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	45,401,023.30	93,510,267.64
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	45,401,023.30	93,510,267.64
3121	Төгрөг	45,401,023.30	93,510,267.64
31211	Төрийн сангийн харилцах	45,401,023.30	93,510,267.64
33	АВЛАГА	279,926.83	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	279,926.83	-
35	БАРАА МАТЕРИАЛ	66,244,957.93	63,959,277.27
351	Түүхий эд материал	433,107.00	1,253,009.40
35110	Тусгай зориулалттай материал	433,107.00	1,253,009.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,881,400.00	1,599,750.00
354	Хангамжийн материал	61,930,450.93	61,106,517.87
35410	Бичиг хэргийн материал	368,800.00	119,300.00
35420	Аж ахуйн материал	347,600.00	-
35460	Хүнсний материал	2,578,869.00	2,301,098.00
35470	Бусад хангамжийн материал	58,635,181.93	58,686,119.87
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	255,306,865.40	511,514,679.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	255,306,865.40	511,514,679.45
392	Биет хөрөнгө	232,075,531.68	488,678,345.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	450,350,601.82	720,030,155.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(310,840,606.88)	(344,469,470.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,500,000.00)	(3,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	87,953,015.40	125,835,315.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,585,439.16)	(62,477,132.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,011,042.66	68,417,906.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,111,364.57)	(31,362,588.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,910,433.00	11,910,433.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,894,274.80)	(11,100,891.64)
39217	Ном	12,282,124.21	11,894,617.97
393	Биет бус хөрөнгө	23,231,333.72	22,836,333.80
39301	Програм хангамж	2,600,000.00	2,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,436,666.28)	(1,531,666.20)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,068,000.00	22,068,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	367,232,773.46	668,984,224.36
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	367,232,773.46	668,984,224.36
51	Засгийн газрын хувь оролцоо	367,232,773.46	668,984,224.36

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	290,346,764.02	290,346,764.02
51101	Өмч: - төрийн	290,346,764.02	290,346,764.02
512	Хуримтлагдсан үр дүн	(385,835,688.90)	(84,084,238.00)
51210	Өмнөх үеийн үр дүн	(385,835,688.90)	(385,835,688.90)
51220	Тайлант үеийн үр дүн	-	301,751,450.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	462,721,698.34	462,721,698.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	367,232,773.46	668,984,224.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	673,342,900.00	1,086,518,582.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	263,246,202.40
120	Нийтлэг татварын бус орлого	-	263,246,202.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	263,121,202.40
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		263,121,202.40
120009	Бусад орлого		125,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	673,342,900.00	823,272,380.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	550,022,400.00	647,097,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	550,022,400.00	647,097,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,320,500.00	176,174,780.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,320,500.00	176,174,780.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	642,248,343.67	783,779,625.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	642,248,343.67	783,779,625.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	638,737,612.67	753,235,996.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,679,266.00	471,724,088.06
210101	Үндсэн цалин	306,051,678.00	353,937,725.26
210102	Нэмэгдэл	74,522,129.00	92,515,309.80
210104	Урамшуулал	23,105,459.00	25,271,053.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,247,567.87	58,242,944.65
210201	Тэтгэврийн даатгал	34,397,678.81	40,047,771.14
210202	Тэтгэмжийн даатгал	4,100,964.99	4,748,862.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,233,731.98	3,772,690.00
210204	Ажилгүйдлийн даатгал	774,107.82	879,419.88
210205	Эрүүл мэндийн даатгал	7,741,084.27	8,794,201.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,423,171.00	120,818,596.84
210301	Гэрэл, цахилгаан	4,981,673.00	7,006,575.58
210302	Түлш, халаалт	86,441,498.00	113,812,021.26
2104	Хангамж, бараа материалын зардал	5,251,927.90	-
210401	Бичиг хэрэг	593,100.00	-

210402	Тээвэр, шатахуун	2,509,705.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	493,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,655,522.90	-
2105	Нормативт зардал	45,994,600.00	26,832,000.00
210502	Хоол, хүнс	45,994,600.00	26,832,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	994,100.00	2,233,000.00
210604	Урсгал засвар	994,100.00	2,233,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	870,000.00	1,895,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	125,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	870,000.00	1,770,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,276,979.90	71,489,866.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,017,540.00	11,877,832.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,970,600.00	4,154,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,288,839.90	55,458,033.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,510,731.00	30,543,629.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	18,900,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	18,900,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,510,731.00	11,643,629.16
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,510,731.00	11,643,629.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	31,094,556.33	302,738,957.14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	987,506.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	987,506.24
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(987,506.24)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	31,094,556.33	301,751,450.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	673,342,900.00	823,397,380.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	125,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	125,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	125,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		125,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	673,342,900.00	823,272,380.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	550,022,400.00	647,097,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	550,022,400.00	647,097,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,320,500.00	176,174,780.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,320,500.00	176,174,780.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	620,694,676.70	763,366,135.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	620,694,676.70	763,366,135.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	594,260,045.70	735,104,156.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,579,295.00	471,535,831.26
210101	Үндсэн цалин	306,353,759.00	349,776,473.46
210102	Нэмэгдэл	74,522,129.00	96,488,304.80
210104	Урамшуулал	22,703,407.00	25,271,053.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,627,465.70	58,151,274.62
210201	Тэтгэврийн даатгал	34,813,767.04	39,960,348.16
210202	Тэтгэмжийн даатгал	4,088,767.39	4,734,267.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,227,333.90	3,771,840.76
210204	Ажилгүйдлийн даатгал	772,508.30	880,437.85
210205	Эрүүл мэндийн даатгал	7,725,089.07	8,804,380.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,423,171.00	120,818,596.84
210301	Гэрэл, цахилгаан	4,981,673.00	5,745,852.21
210302	Түлш, халаалт	86,441,498.00	115,072,744.63
2104	Хангамж, бараа материалын зардал	262,100.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	262,100.00	-
2105	Нормативт зардал	29,530,969.00	26,554,229.00
210502	Хоол, хүнс	29,530,969.00	26,554,229.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	994,100.00	43,712,554.00
210604	Урсгал засвар	994,100.00	43,712,554.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	870,000.00	1,895,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	125,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	870,000.00	1,770,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,972,945.00	12,436,170.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,612,445.00	8,583,470.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,360,500.00	3,852,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,434,631.00	28,261,979.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,923,900.00	16,618,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,923,900.00	16,618,350.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,510,731.00	11,643,629.16
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,510,731.00	11,643,629.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	52,648,223.30	60,031,244.34
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,495,000.00	11,922,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,495,000.00	11,922,000.00

2200	Дотоод эх үүсвэрээр	7,495,000.00	11,922,000.00
222001	Тоног төхөөрөмж	7,495,000.00	11,922,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,495,000.00)	(11,922,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	45,153,223.30	48,109,244.34
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		45,401,023.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,401,023.30	93,510,267.64

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(443,926,791.68)	309,141,670.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,639,822.95)	(1,639,822.95)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(445,566,614.63)	307,501,847.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	59,730,925.73	59,730,925.73
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(385,835,688.90)	367,232,773.46
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(385,835,688.90)	367,232,773.46
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(385,835,688.90)	367,232,773.46
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	301,751,450.90	301,751,450.90
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(84,084,238.00)	668,984,224.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	646,172,400.00	625,115,837.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	646,172,400.00	617,620,837.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	623,237,900.00	594,696,937.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,815,900.00	404,016,187.00
210101	Үндсэн цалин	312,652,500.00	306,790,651.00
210102	Нэмэгдэл	94,352,600.00	74,522,129.00
210104	Урамшуулал	7,810,800.00	22,703,407.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,851,800.00	50,627,465.70
210201	Тэтгэврийн даатгал	35,259,300.00	34,813,767.04
210202	Тэтгэмжийн даатгал	4,148,100.00	4,088,767.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,318,500.00	3,227,333.90
210204	Ажилгүйдлийн даатгал	829,600.00	772,508.30
210205	Эрүүл мэндийн даатгал	8,296,300.00	7,725,089.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,150,000.00	91,423,171.00
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	4,981,673.00
210302	Түлш, халаалт	91,350,000.00	86,441,498.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	262,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	262,100.00
2105	Нормативт зардал	31,345,200.00	29,530,969.00
210502	Хоол, хүнс	31,345,200.00	29,530,969.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	994,100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	994,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,384,200.00	870,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,384,200.00	870,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,690,800.00	16,972,945.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,330,300.00	11,612,445.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,360,500.00	5,360,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,934,500.00	22,923,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,934,500.00	22,923,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,934,500.00	22,923,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	7,495,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	7,495,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	7,495,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	739,418,700.00	673,342,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	550,022,400.00	550,022,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	550,022,400.00	550,022,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	189,396,300.00	123,320,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	189,396,300.00	123,320,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		45,401,023.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		93,510,267.64

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Орхон сумын ЕБС нь бүрэн дунд боловсролын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд нийт 32 орон тоогоор ажиллаж “Хүүхэд нэг бүрийн сурах боломжоор хангаж, авьяасыг нээн хөгжүүлэн бие даан суралцах чадвартай, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлнэ.” гэсэн зорилт дэвшүүлж ажиллажээ. Аймгийн засаг даргын "Шинэ зам мөрийн хөтөлбөр"-ийн дэд хөтөлбөр "Шинэ багш", "Шинэ Ирээдүй" хөтөлбөрүүдийг хэрэгжижүүлж байна.

Сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эхний хагас жилд "Хангалттай" үнэлгээ, 2022-2023 оны хичээлийн жилд БҮТ-өөс гаргасан байгууллагын хөндлөнгийн үнэлгээгээр 74 хувьтай IV түвшинд үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгал, Татварын багц хуулиуд, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол, "Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагуудын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дугаар тогтоол, БШУС-ын 2023.06.13-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1а/2714 албан бичгээр ЕБС, цэцэрлэгийн нөхөн хангалтыг шийдвэрлэх талаар ирүүлсэн чиглэл зэрэг тайлант онд дээд шатны эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагыг хянан баталж дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг цахимаар хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон сумын ЕБС-ийн 2023 оны санхүүгийн тайланг УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 301,751.4 мянган төгрөгөөр буюу 82.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	45,401.0	93,510.3	48,109.3
Авлага	279.9	-	(279.9)
Бараа материал	66,244.9	63,959.3	(2,285.6)
Үндсэн хөрөнгө	659,675.2	965,956.4	306,281.2
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(404,368.3)	(511,514.7)	(107,146.4)
Нийт хөрөнгө	<u>367,232.8</u>	668,984.2	<u>301,751.4</u>
Өр төлбөр			233.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<u>367,232.8</u>	668,984.2	301,751.4
Өр төлбөр /богино хугацаат/			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>367,232.8</u>	668,984.2	<u>301,751.4</u>

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 93,510.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх үлдэгдлийн 88.0 хувь буюу 69,241.7 мянган төгрөг нь цалингийн зардлаас, 9,446.4 мянган төгрөг нь ажил олгогчоос төлөх НДШ, 7,892.3 мянган төгрөг нь хүүхдийн хоолны зардлаас зарцуулагдаагүй үлдсэн нь орон тоо дутуу ажилласан, хүүхдийн тооны зөрүүгээс тус тус шалтгаалсан байна.

Бараа материал өмнөх оноос 2,285.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 668,984.2 мянган төгрөг болж өмнөх оноос 306,281.2 мянган төгрөгөөр өсчээ. БШУС-ын 2023 оны А/230 дугаар тушаалаар хуваарилсан нөхөн хангалтын санхүүжилтээс 11,922.0 мянган төгрөгөөр сургалтын тоног төхөөрөмжийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжид нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллажээ. Хичээлин

байрад 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 228,000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хигдсэн их засварын ажлыг хүлээн авч, 3,900.0 мянган төгрөгөр тавилга, эд хогшил авч, жилийн эцэст төсвийн хөрөнгөөр дотуур байранд 9,900,0 мянган төгрөгийн, БШУГ-ын хөрөнгө оруулалтаар 10,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч, бүртгэлд тусгасан байна.

Тайлант хугацаанд 55,458.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 668,984.2 мянган төгрөг болж 301,751.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт орлого өмнөх оноос 384,539.3 мянган төгрөгөөр буюу 54.8 хувиар өсөхөд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө өмнөх оноос 234,609.8 мянган төгрөгөөр, санхүүжилтийн орлого 149,929.5 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Урсгал зардал өмнөх оноос 141,531.3 мянган төгрөгөөр өсчээ. Үүний 82.5 хувь буюу 116,751.6 мянган төгрөг нь цалин, хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2023 оны анхны төсвийг 564,596.2 төгрөгөөр баталсныг тайлант онд 2 удаа өөрчлөлт оруулж, тодотгон оны эцэст 647,097.6 мянган төгрөгөөр буюу 82,501.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ. Энэ нь тайлант онд цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 647,097.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 141,180.7 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 788,278.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 93,510.3 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / мянган төгрөгөөр/

Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	1,029.0	1,029.0	0	100
	2	80312- Сургалт семинар	521.3	486.7	34.6	93.4
	3	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,029.0	983.0	46.0	95.5
	4	81801- Үдийн цай хөтөлбөр	24,510.7	16,618.3	7,892.3	67.8
	5	81806-Дотуур байрны хүүхдийн хоол	50,152.9	43,891.6	6,261,3	87.5
	6	81816- Монгол хүүхдэд үндэсний хөтөлбөр	11,114.6	11,114.6	0	100
	7	81823- Боловсролын багшийн сургалт	3,262.9	2,823.0	439.9	86.5
	8	81827-Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	2,044.4	709.6	1,334.7	68.9

9	81834- Боловсролын стандарт сургалт	432,048.3	416.747.4	15,300.9	96.5
10	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	120,369.1	105,532.8	14,836.3	87.7
11	81848-Сурах бичгийн түрээс	743.4	125.0	618.4	16.8
	Эхний үлдэгдэл			45,401.0	
Нийт		833,672.1	775,288.1	93,510.3	93.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн ахлах аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Д.Туяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ЦЭСБ аудит ХХК-ийн захирал Ч.Цэрэннадмид хэрэгжүүлж дараагийн хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын ЕБС нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 366,459.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,790.2 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын дүнгээс 80 хувиар тооцон 7,032.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтуудтай холбоотой зардлыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон сумын ЕБС-ийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн зөрчилд 680.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 66,244.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,127.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	680.5	1	680.5	100
Албан шаардлага	1	66,244.9	1	66,244.9	100
Зөвлөмж	1	4,127.5	1	4,127.5	100
Нийт дүн	3	71,052.9	3	71,052.9	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

